ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2023/63/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэт хот

2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn


2023. 02. 24 № 83

танай_____________-ны №______________-т

ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИРЫН, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны тайлангийн хугацаанд Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд солигдсон боловч ажил хүлээлцэж, тооллого хийгээгүй. Мөн хагас жил болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулаагүй байна.

**Аудитын гол асуудал**

Орхон аймгийн Биеийн тамир спортын газар нь орон нутгийн төсвийн санхүүжилтээр улсын болон аймагт зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаануудын зардлыг төсвийн дагуу батлуулан зарцуулахдаа холбогдох спортын холбоодод мөнгийг шилжүүлдэг боловч тайлан тооцоо хангалтгүй хийгдсэн байна.

D:\my doc \alban bichig\2023-A4.doc

**Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн тайланд 673.8 мянган хөрөнгийн арилжааны банк дампуурах үед үүссэн барагдуулах боломжгүй авлага бүртгэлтэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,987,810.20** | **69,766,872.20** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 32,000.00 | 32,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 32,000.00 | 32,000.00 |
| **3121** | **Төгрөг** | 32,000.00 | 32,000.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 32,000.00 | 32,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 673,824.74 | 673,824.74 |
| **335** | **Бусад авлага** | 673,824.74 | 673,824.74 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 673,824.74 | 673,824.74 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 26,281,985.46 | 69,061,047.46 |
| **351** | **Түүхий эд материал** | 19,680,881.00 | 64,427,381.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19,680,881.00 | 64,427,381.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 6,601,104.46 | 4,633,666.46 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 415,438.00 | 428,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 430,000.00 | 7,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,713,666.46 | 2,790,666.46 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,407,000.00 | 1,407,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,372,740,180.56** | **7,190,721,579.46** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 7,372,740,180.56 | 7,190,721,579.46 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,186,340,180.56 | 7,004,321,579.46 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,746,550,562.71 | 7,746,550,562.71 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (845,449,489.31) | (993,832,683.59) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 72,200,000.00 | 72,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (38,309,999.96) | (43,910,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 47,530,635.00 | 52,451,155.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (26,362,637.80) | (32,429,592.35) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 91,636,439.50 | 91,636,439.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (65,857,180.76) | (70,407,142.34) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 661,511,515.94 | 661,511,515.94 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (457,109,664.76) | (479,448,676.23) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 186,400,000.00 | 186,400,000.00 |
| 39301 | Программ хангамж | 850,000.00 | 850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (850,000.00) | (850,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 186,400,000.00 | 186,400,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,399,727,990.76** | **7,260,488,451.66** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **538,610.50** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 538,610.50 |
| 413 | Өглөг | - | 538,610.50 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 538,610.50 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,399,727,990.76** | **7,259,949,841.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,399,727,990.76 | 7,259,949,841.16 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 566,471,747.87 | 426,693,598.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 566,471,747.87 | 566,471,747.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (139,778,149.60) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,674,458,393.55 | 1,674,458,393.55 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,399,727,990.76** | **7,259,949,841.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **891,453,433.16** | **839,995,986.82** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **458,917,950.00** | **24,364,778.82** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 458,917,950.00 | 26,194,778.82 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 458,917,950.00 | 26,194,778.82 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,666,450.00 | 21,974,258.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 448,320,000.00 | 2,390,520.82 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **432,535,483.16** | **813,801,208.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 347,322,800.00 | 406,756,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 347,322,800.00 | 406,756,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 61,712,683.16 | 277,019,908.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 52,938,683.16 | 270,230,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 6,789,408.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,500,000.00 | 130,024,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,500,000.00 | 86,973,400.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 43,051,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **589,568,279.39** | **979,774,136.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **589,568,279.39** | **979,774,136.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 548,944,759.16 | 913,923,165.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 285,762,122.84 | 325,811,281.43 |
| 210101 | Үндсэн цалин | 221,935,192.00 | 222,584,057.62 |
| 210102 | Нэмэгдэл | 50,117,530.84 | 68,753,603.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13,709,400.00 | 19,179,498.89 |
| 210104 | Урамшуулал | - | 15,294,121.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,900,643.01 | 43,307,133.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,834,799.30 | 28,385,620.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,390,662.03 | 5,474,630.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,942,433.78 | 2,641,607.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 457,754.03 | 618,824.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,274,993.87 | 6,186,450.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,866,895.00 | 26,239,784.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,144,347.00 | 8,068,668.35 |
| 210302 | Түлш, халаалт | 13,378,197.00 | 14,217,797.97 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,344,351.00 | 3,953,318.51 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,584,624.00 | 9,135,145.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,025,340.00 | 1,386,388 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,455,000.00 | 2,130,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 902,184.00 | 1,033,257.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 208,000.00 | 572,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,896,100.00 | 4,013,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,099,000.00 | 29,876,308.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,530,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,099,000.00 | 27,346,308.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 921,000.00 | 1,533,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 921,000.00 | 1,533,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,452,911.00 | 2,409,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,277,300.00 | 60,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | 344,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 142,750.00 | 201,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 350,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,256,861.00 | 1,420,760.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,357,563.31 | 475,611,031.92 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,905,769.97 | 287,771,910.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 900,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 103,451,793.34 | 186,939,121.92 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,623,520.23 | 65,850,970.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,070,500.00 | 17,164,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,513,000.00 | 15,974,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,557,500.00 | 1,370,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 21,553,020.23 | 48,686,970.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,553,020.23 | |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 48,686,970.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **301,885,153.77** | **(139,778,149.60)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **301,610,154.17** | **(139,778,149.60)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **457,592,033.16** | **794,203,966.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,597,950.00** | **25,984,258.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,597,950.00 | 25,984,258.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,597,950.00 | 25,984,258.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,666,450.00 | 24,154,258.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,931,500.00 | 1,830,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **446,994,083.16** | **768,219,708.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 347,322,800.00 | 406,756,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 347,322,800.00 | 406,756,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74,832,683.16 | 274,489,908.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 52,938,683.16 | 267,700,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,120,000.00 | 6,789,408.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,500,000.00 | 86,973,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,500,000.00 | 86,973,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **445,432,033.16** | **791,673,966.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **445,432,033.16** | **791,673,966.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **403,457,412.93** | **717,543,587.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 286,458,692.84 | 325,272,670.93 |
| 210101 | Үндсэн цалин | 217,927,431.00 | 222,045,447.12 |
| 210102 | Нэмэгдэл | 53,490,786.54 | 68,753,603.92 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,040,475.30 | 19,179,498.89 |
| 210104 | Урамшуулал | - | 15,294,121.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,941,267.01 | 43,307,133.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,314,110.91 | 28,385,620.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,419,622.61 | 5,474,630.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,877,758.59 | 2,641,607.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 461,006.28 | 618,824.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,868,768.62 | 6,186,450.89 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,411,968.11 | 26,239,784.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,689,420.11 | 8,068,668.35 |
| 210302 | Түлш, халаалт | 13,378,197.00 | 14,217,797.97 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,344,351.00 | 3,953,318.51 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,173,304.00 | 8,460,707.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 703,820.00 | 1,399,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,160,000.00 | 1,495,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 902,184.00 | 1,033,257.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 333,000.00 | 572,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,074,300.00 | 3,961,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 195,000.00 | 20,158,900.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 20,158,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 921,000.00 | 1,533,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 921,000.00 | 1,533,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,166,911.00 | 2,949,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,287,300.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 344,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 162,750.00 | 201,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,256,861.00 | 1,420,760.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 42,189,269.97 | 289,621,910.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,189,269.97 | 288,721,910.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,974,620.23** | **74,130,378.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,421,600.00 | 25,443,408.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,338,600.00 | 8,279,408.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,513,000.00 | 15,794,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,570,000.00 | 1,370,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,160,000.00** | **48,686,970.48** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,880,000.00** | **2,530,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,880,000.00** | **2,530,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,880,000.00 | 2,530,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 12,880,000.00 | 2,530,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(12,880,000.00)** | **(2,530,000.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 32,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 32,000.00 |

### 4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,158,797,849.34 | 1,674,458,393.55 | 566,471,747.87 | 7,399,727,990.76 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,158,797,849.34** | **1,674,458,393.55** | **566,471,747.87** | 7,399,727,990.76 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (139,221,540.10) | (139,221,540.10) |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,158,797,849.34** | **1,674,458,393.55** | **566,471,747.87** | 7,399,727,990.76 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **5,158,797,849.34** | **1,674,458,393.55** | **566,471,747.87** | 7,399,727,990.76 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,158,797,849.34** | **1,674,458,393.55** | **566,471,747.87** | 7,399,727,990.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (139,778,149.60) | (139,778,149.60) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,158,797,849.34** | **1,674,458,393.55** | **426,693,598.27** | 7,259,949,841.16 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **406,756,400.00** | **395,858,720.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **406,756,400.00** | **395,858,720.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **389,497,400.00** | **378,694,720.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **268,638,900.00** | **262,192,172.00** |
| 210101 | Үндсэн цалин | 201,499,100.00 | 176,096,595.00 |
| 210102 | Нэмэгдэл | 33,505,600.00 | 55,836,456.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 15,685,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,734,200.00 | 14,574,121.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,579,900.00** | **33,569,880.20** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,834,300.00 | 23,873,553.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,686,400.00 | 2,538,899.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,149,100.00 | 2,031,119.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 537,300.00 | 466,027.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,372,800.00 | 4,660,279.79 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,666,600.00** | **4,869,707.97** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,400,300.00 | 1,399,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,860,000.00 | 1,495,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,464,300.00 | 1,033,257.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 572,000.00 | 572,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 370,000.00 | 370,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,916,000.00** | **1,533,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,916,000.00 | 1,533,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,017,200.00** | **2,949,480.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,430,000.00 | 450,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 344,300.00 | 344,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 288,700.00 | 201,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,421,200.00 | 1,420,760.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **74,678,800.00** | **73,580,480.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,762,800.00 | 72,680,480.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,916,000.00 | 900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,259,000.00** | **17,164,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **17,259,000.00** | **17,164,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,794,000.00 | 15,794,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,465,000.00 | 1,370,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **406,756,400.00** | **406,756,400.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **406,756,400.00** | **406,756,400.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 406,756,400.00 | 406,756,400.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **275,267,480.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **272,737,480.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 270,907,480.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 31,598,726.12 |
| 210101 | Үндсэн цалин | - | 23,687,329.12 |
| 210102 | Нэмэгдэл | - | 6,147,397.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 1,044,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 720,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 3,485,853.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 2,433,912.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 262,985.06 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 210,388.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 52,597.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 525,971.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 3,619,970.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 3,619,970.54 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 16,161,500.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 16,161,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 216,041,430.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 216,041,430.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 1,830,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 1,830,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | 1,830,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,530,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 2,530,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,530,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 274,489,908.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 274,489,908.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 267,700,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 6,789,408.00 |

## 2.7 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн орон нутгийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **86,973,400.00** | **67,941,387.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,973,400.00** | **67,941,387.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **86,973,400.00** | **67,941,387.10** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **49,820,000.00** | **31,481,772.81** |
| 210101 | Үндсэн цалин | 30,507,500.00 | 22,261,523.00 |
| 210102 | Нэмэгдэл | 4,318,500.00 | 6,769,750.92 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,994,000.00 | 2,450,498.89 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,251,400.00** | **6,251,400.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,250,600.00 | 2,078,154.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 500,300.00 | 2,672,745.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 400,100.00 | 400,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 100,200.00 | 100,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,000,200.00 | 1,000,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **23,311,000.00** | **22,619,814.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,230,500.00 | 4,448,697.81 |
| 210302 | Түлш, халаалт | 13,811,000.00 | 14,217,797.97 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,269,500.00 | 3,953,318.51 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,591,000.00** | **3,591,000.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,591,000.00 | 3,591,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,000,000.00** | **3,997,400.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 3,997,400.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **86,973,400.00** | **67,941,387.10** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **86,973,400.00** | **67,941,387.10** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 86,973,400.00 | 67,941,387.10 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **25.00** | **25.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **12.00** | **12.00** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **12.00** | **12.00** |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 12.00 | 12.00 |

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

Аудитаар орлого үр дүнгийн тайланд 6,554.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 6,554.7 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Үүнд: 126.8 мянган төгрөг бичиг хэргийн зардлыг тээвэр шатахууны зардалд, урсгал засварын зардлыг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 6,427.9 мянган төгрөгийг зарлагадаж зардал хооронд гүйлгэсэн байна.

Аудитаар нийт 4,862.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,424.3 мянган төгрөгийн 2 төлбөр акт тогтоож, 2,230.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,208.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

**1. Төлбөрийн акт**

1. Цахим төлбөрийн баримтгүй 33,079.4 төгрөгийн, хувь хүний сугалааны дугаартай баримтаар 361,176 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

2. Улаанбаатар хот, аймаг орон нутагт зохион байгуулагдсан тэмцээн уралдааны зардлыг холбогдох спортын холбоодод олгодог боловч уралдаан тэмцээний шагнал, шүүгчийн хөлсийг өгсөн талаар баталгаажуулаагүй, тайлан тооцоо, өргөмжлөл, цом, медаль худалдан авсан баримт байхгүй зэрэг бусад холбогдох нотлох баримтгүй 1,030,000 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**2. Албан шаардлага**

1. Шатахуун зарцуулахдаа жолоочийн замын хуудсанд явсан километр, маршрут, ямар ажил үүргээр явсан талаар тодорхой бичээгүй, зарцуулалтын нормыг тодорхойлоогүй, сард аймаг дотор 1,283 км явснаар бөглөсөн, 2,230,000 төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо шаардлага хангахгүй, хяналт хийгдээгүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 41.2.3.-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэж заасныг хэрэгжүүлээгүй, Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-той нийцэхгүй байна.

2. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудаст 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3.-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

***<u>Илрүүлэлт</u>:*** Цалингийн дансанд сорил гүйцэтгэхэд ажил хавсран гүйцэтгэж буй ажилтны цалингийн хувь алдаатай тооцогдсон, ажилтны ажилласан хоног цагийн бүртгэлтэй тохироогүй, байгууллагын даргын тушаалын дагуу тооцогдоогүй зэргээс шалтгаалан 438.2 мянган төгрөгийн цалинг илүү, 95.2 мянган төгрөгийн цалинг дутуу тооцсон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3-т "Гүйцэтгэсэн ажил үүрэгтэй тохирсон цалин хөлс авах", 43.2.1-д "Гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирсон цалин хөлсийг тогтоосон хугацаанд ажилтанд олгох, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр тогтоогоогүй бол хөдөлмөрийн нормыг үндэслэлтэй тогтоох, аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөж байгаа цалин хөлсний тогтолцоо, журмыг ажилтанд мэдээлэх" гэсэн заалтууд зөрчигдсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Ажилчдын цалинг бодохдоо үнэн зөв тооцож, суутгах татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв, заавар журмын дагуу бодох.

**2. Үндсэн хөрөнгө тооллого холбоотой асуудал**

***<u>Илрүүлэлт</u>:*** Тайлангийн хугацаанд байгууллагын нягтлан бодогч солигдсон боловч ажил хүлээлцэж тооллого тооцоо хийгээгүй, хагас жилээр хөрөнгийн тооллого хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”, 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Хөрөнгийн тооллогыг хууль, журамд заасан хугацаанд тогтмол явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж, тайлагнах.

**3. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

***<u>Илрүүлэлт</u>:*** Тайлант хугацаанд тэмцээн уралдааны зардлаас 136.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварт төлөөгүй, ажилчдын цалингаас 538.6 мянган төгрөгийн татварын өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19.1.1-д "урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр" 21.2.2-т "энэ хуулийн 19.1.1-д заасан орлогын дүнд 5 хувиар", 6.3.-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Хувь хүний орлогын албан татварыг үнэн зөв тооцож, өглөг үүсгэхгүй ажиллах

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бичиг хэрэг 126.8 төгрөг болон урсгал засварын 6.427.9 төгрөгийг Бараа материалын орлого болон зарлага дансанд сонгоогүй бүртгэсэн зарлага баримт дансанд сольж бүртгэсэн. | 1 | 6,554.7 | | | 1 | 6,554.7 | 1 | 6,554.7 | | | | |
| **Дүн** | 1 | 6,554.7 | | | 1 | 6,554.7 | 1 | 6,554.7 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим төлбөрийн баримтгүй 33.1 мянган төгрөгийн, хувь хүний сугалааны дугаартай 361.2 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. | 1 | 394.3 | 1 | 394.3 | | | | | | | | |
| Цалингийн дансанд сорил гүйцэтгэхэд ажил хавсран гүйцэтгэж буй ажилтны цалингийн хувь алдаатай тооцогдсон, ажилтны ажилласан хоног цагийн бүртгэлтэй тохироогүй, байгууллагын даргын тушаалын дагуу тооцогдоогүй зэргээс шалтгаалан 438.2 мянган төгрөгийн цалинг илүү, 95.2 мянган төгрөгийн цалинг дутуу тооцсон байна. | 1 | 533.5 | | | | | 1 | 533.5 | | | | |
| Тайлангийн хугацаанд байгууллагын нягтлан бодогч солигдсон боловч ажил хүлээлцэж тооллого тооцоо хийгээгүй, хагас жилээр хөрөнгийн тооллого хийгдээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шатахуун зарцуулахдаа жолоочийн замын хуудсанд явсан километр маршрутыг тодорхой бичээгүй, зарцуулалтыг нормыг тодорхойлоогүй, ямар ажил үүргээр зарцуулж байгаа нь тодорхойгүй, байгууллагын дарга сард аймаг дотор 1283км явсан гэж бөглөсөн байна. 2,230.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо шаардлага хангахгүй, хяналт хийгдээгүй байна. | 1 | 2,230.0 | | | 1 | 2,230.0 | | | | | | |
| Тайлант хугацаанд тэмцээн уралдааны зардлаас 136.0 мянган төгрөгийн ХХОАТ төлөөгүй, ажилчдын цалингаас 538.6 мянган төгрөгийн ХХОАТ-ийн өглөг үүссэн байна. | 1 | 674.6 | | | | | 1 | 674.6 | | | | |
| Аймгийн ЗД-ын захирамжаар болон орон нутгийн төсвөөр санхүүжин улс болон аймагт зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаануудын зардлыг төсвийн дагуу батлуулан зарцуулахдаа холбогдох спортын холбоодуудад мөнгийг шилжүүлдэг боловч тайлан тооцоо баримт байхгүй, уралдаан тэмцээнүүдийн шагнал, шүүгчийн цалин зэргийг өгснөө баталгаажуулдаггүй, өргөмжлөл, цом, медаль худалдан авсан баримт болон бусад холбогдох баримтууд байхгүй зэрэг зөрчлүүд байна. Нотлох баримтгүй, мөнгийг гарган зарцуулсан боловч мөнгөөр байхгүй, огт баримтгүй 1,030.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. | 1 | 1,030.0 | 1 | 1,030.0 | | | | | | | | |
| **Дүн** | **6** | **4,862.4** | **2** | **1,424.3** | **1** | **2,230.0** | **3** | **1,208.1** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд мэдээлбэл зохих 161 талбарын мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | | |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | 1 | 1 | | | 1 | | | |